МЭДЭЭ · 2020 оны 3-р сарын 24

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭДЭЭЛЭЛ ХИЙЖЭЭ



Увс аймгийн Прокурорын газраас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд орон нутгийнхаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан аймгийн хэмжээнд энэ оны 3 сарын байдлаар үйлдэгдсэн танхайрах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, мөн Зөрчлийн болон Эрүүгийн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар мэдээлэл хийжээ.

Цаашид тус аймгийн прокурорын газар нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн телевизтэй хамтран мэдээ, мэдээлэл бэлтгэх, зохиомжит шторк хийж олон нийтэд хүргэх зэрэг ажлыг хийхээр болсон байна.

УВС АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3076